

Эцгийн захиас

Ганц хүүтэй ядуу тариачин нас барахынхаа өмнө эхнэртээ

“Хүүгээ л эрдэмтэй сайн хүн болгоорой. Тэгвэл хүн бүхэн хүндэтгэнэ” гэж захижээ.

Хүүг долоон нас хүрмэгц эх нь:

-Одоо чи эцгийнхээ гэрээсийг биелүүлэх цаг нь болжээ. Чамд эрдэм сурах арван жилийн хугацаа өгье. Тэгснийхээ дараа хотод очиж шалгалт өгөөд, эрдэмтэн болж чадна” гэж хэлэв. Хүү хот руу явсан боловч хугацаанаасаа өмнө эргэж ирэхэд эх нь хүүгээ санасан хэдий ч сэтгэлээ барин:

-Чи яагаад хугацаанаас өмнө ирэв? Шалгалт өгч чадахаар ном эрэм сурчхаа юу? гэж асуухад, хүү нь уйлж, “Идэх юм өгөөч.” гэв.

-Би тандаа ирэх гэж яараад арван жил сурах эрдмийг наана нь сурчихсан гэхэд эх нь:

-Тэгвэл чи эхний арван үсгийг харанхуйд бич гээд гэрлээ унтраахад, хүү ч үсгээ бичиж, эх нь боорцог хийжээ. Хүүгийн бичсэн үсгүүд том жижиг, хэд хэдэн газар бэх дусаасан байхад ээжийнх нь хийсэн боорцог цэв цэвэрхэн сайхан болсон байв. Ээж нь хүүгээ гэртээ байлгахыг хэчнээн их хүсэж байсан ч

“-Эрдмээ өөрийн болгоод сураад ир.” гэж тэр шөнөдөө явуулжээ.

1. Асуултын зөв хариуг сонгоорой.

/5оноо/

А. Хүү хэдэн удаа гэрээсээ явсан бэ?

- а. 1 б. 2 с. 3

Б. Хүү хугацаанаасаа өмнө ирдгийн учир юу вэ?

- а. Ихэд өлсөж ядарсан
б. Ээждээ ирэхээр яарсан
с. Сурах зүйлээ сайн сурсан

В. Ээж нь яагаад гэрлээ унтраасан бэ?

- а. Үсэг бичихэд хэцүү болгох гэж
б. Хүүгээ буцааж эрдэм сурахаар явуулах гэж
с. Төгс сайн сурсан байна уу гэж шалгахаар

Г. Ээжийн хэлсэн “Эрдмээ өөрийн болгоод сураад ир” гэсэнд тохирох зүйр үгийг олж тэмдэглэ.

- а. Эрдмийг хичээлээр сурдаг, эрлийг сургаар олдог
б. Ах нь хүндэлж, дүү нь сургадаг
с. Хүн ахтай, дээл захтай

Д. “Эцгийн захиас” эхэд гарсан агуулгыг олж тэмдэглээрэй.

- а. Хүүгийн мунхгийн тухай
б. Эцгийн захиасын тухай
с. Эрдэм сурахын ашиг тусын тухай

2. Эхийг уншаад өөрт төрсөн сэтгэгдлээ 30 орчим үгээр илэрхийлж бичээрэй. /3оноо/

3. “Харин, үүнээс болж, яагаад гэвэл, ийм учраас” холбох үгийг ашиглан дараах өгүүлбэртэй утгын холбоотой өгүүлбэр зохион бичээрэй **/2 оноо/**
Саран тоо бодох дуртай.

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....

4. Хэлц үгийн утгыг тайлбарлаж, өгүүлбэрт оруулан бичээрэй. **/3оноо/**

Галуу дуурайж хэрээ хөлөө хөлдөөх-
Ном хаялцах-
Нар баруунаас гарах-

-
-
-

5. Найздаа бахархсан утгатай захидал бичээрэй. **/3оноо/**



..... оны дугаар сарын

-
-
-
-
-

Захидал бичсэн: Хайртай

6.Зүйр үгийг гүйцээн бичээрэй. **/2оноо/**

Үнэн үг үнэд хүрнэ
.....үг хор хүргэнэ

..... өлөн бугын эвэр.....
Цадахад цагаан хурганы сүүл

Уурласан бүхэн биш
..... бүхэн биш

..... санах сэрэх
Уруудахад унтах идэх

7.“аргал - аргаль, тууль- туйл” үгсээр утга ялгасан өгүүлбэр зохион бичээрэй. **/2оноо/**

-
-
-
-

8. Үгсэд өгөгдсөн залгаврыг залгаж, дүрмийг таайлбарлан бичээрэй. **/4оноо/**


- саравч + л =.....
- урагш + л =.....
- шилж + х =
- идээш + ж =

Сургууль анги сурагчийн нэр

Математик 4-р анги


1. Хоёр тооны нийлбэр 10000, тэдгээрийн ялгавар 6000 бол уул хоёр тоог олоорой. **/2 оноо/**

2. Дүрсүүдийг шинжээр нь хүснэгтэд ангилж тоог нь бичээрэй. **/2 оноо/**



	Тэгш хэмтэй	Тэгш хэмгүй
Параллель талтай		
Параллель талгүй		


3. Ангийн сурагчдын 6 нь А, 7 нь В, 10 нь С, 11 нь D үнэлгээтэй шалгагдсан бол багана диаграммаар дүрслээрэй. Анги нийт хэдэн хүүхэдтэй вэ? **/1.5 оноо/**



4. Цэгийн оронд тохирох тоог бичээрэй. **/1.5 оноо/**

$\frac{1}{5}$ м = см $\frac{9}{10}$ л = мм $\frac{5}{4}$ кг = ... г

5. Холимог бутархайг тоон шулуун болон загварт дүрслээрэй. **/2 оноо/**



6. $\frac{8}{3}$ -ыг холимог бутархайд шилжүүлснийг сонгоорой. **/1 оноо/**

- A. $2\frac{3}{2}$ B. $3\frac{2}{3}$ C. $2\frac{2}{3}$ D. $3\frac{3}{2}$

7. Үл мэдэгдэх тоог олоорой. **/1 оноо/**

$15\frac{21}{28} - X = \frac{16}{28}$

8. Илэрхийллийг бодоорой. **/2 оноо/**

$2354 + 6708 : 26 - 25 \times 18 =$


.....

9. Биетийн эзэлхүүний хэмжээг олоорой.

/1 оноо/



1 см куб



..... см куб

10. Агуулахын өргөн нь 6м, урт нь 4 м, эзлэхүүний хэмжээ 72м куб бол өндрийн хэмжээг олоорой.

/1 оноо/

11.Хүснэгтийг нөхөөрэй.

/1.5 оноо/

	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Зайрмаг	25	1200	
Чихэр		500	40000
Жигнэмэг	18		4500


12. Хэдэн гурвалжин байна вэ?

/1.5 оноо/



13.Графикийг ажиглаад даалгаврыг гүйцэтгээрэй

/4оноо/



а. Хүснэгтийг нөхөөрэй.

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Агаарын хэм	2°											

б. Аль сард хамгийн халуун байна вэ?

в. 4 дүгээр сард хэдэн хэмийн дулаан байсан бэ?

г. 9 ба 11 дүгээр сарын агаарын хэмийн зөрөөг олоорой.

Бүгд оноо- 22 оноо

Нийт- 17оноо

СУРГУУЛЬ..... АНГИ..... СУРАГЧИЙН НЭР.....

Математик 3-р анги

Нийт-17оноо